



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/100

Чингис хот

Үнэлгээний хорсо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хооронд байгуулсан “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилт төслийн санхүүжилтээр 2021 онд Хэнтий аймагт хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны
дарга:

Ц.Чогсомжав

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн
дарга:

Ч.Мөнх-Эрдэнэ

Аймаг хариуцсан төслийн ажилтан

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Саранцэцэг

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, аж ахуйн албаны дарга

Ц.Мөнхтулга

Мал эмнэлгийн газрын Захиргаа, санхүүгийн албаны дарга

Б.Цэрэнчимэд

Бэлчээр ашиглагчдын холбооны гүйцэтгэх захирал


Д.Оюун

Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010293

Аймгийн Засаг даргын 2021 оны
...02 дугаар сарын 25 өдрийн А/100
дугаар захирамжийн хавсралт

“ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ” НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ ТӨСЛИЙН
ХҮРЭЭНД ХЭНТИЙ АЙМАГТ 2021 ОНД ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВ

Д/д	Худалдан авалт	Худалдан авалтын арга	Тоо хэмжээ	Нийт төсөвт өртөг /төгрөг/	Төслөөс /төгрөг/	Орон нутгаас /төгрөг/
1	Инженерийн хийцтэй шинэ худаг	НТШ	5	115,000,000	80,500,000	34,500,000
2	Мал угаалгын суурин ванн шинээр барих	НТШ	7	105,000,000	73,500,000	31,500,000
3	Борлуулалтын цэг шинээр барих	НТШ	2	240,000,000	168,000,000	72,000,000
4	Хүнсний ногооны зоорь шинээр барих	НТШ	1	130,000,000	91,000,000	39,000,000
5	Бизнес төв, борлуулалтын цэгийн дэмжлэг	НТШ	2	40,000,000	28,000,000	12,000,000
6	Хөдөө аж ахуйн газрын байрны засвар	НТШ	1	294,000,000	205,800,000	88,200,000
	Дүн			924,000,000	646,800,000	277,200,000